



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/241

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.5.8, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тендерийн баримт бичиг боловсруулах бичиг хэргийн зардалд 240,000 (хоёр зуун дөчин мянга) төгрөг, Байгаль орчны хяналтын ажлын бичиг хэргийн зардалд 571,000 (таван зуун далан нэгэн мянган) төгрөг, нийт 811,000 (найман зуун арван нэгэн мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 240,000 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийг Эрсдлээс хамгаалах сангаас, 571,000 (таван зуун далан нэгэн мянган) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас тус тус зарцуулахыг сумын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН